



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2022 оны 06 сарын 09 өдөр

Дугаар 223

Улаанбаатар хот

“Эрдэнэт үйлдвэр” төрийн өмчит үйлдвэрийн
газрын зохион байгуулалтын бүтэц,
орон тооны хязгаарыг өөрчлөн батлах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 9, 18 дугаар зүйлийн 5 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Эрдэнэт үйлдвэр” төрийн өмчит үйлдвэрийн газрын зохион байгуулалтын бүтцийг хавсралт ёсоор өөрчлөн баталсугай.

2. “Эрдэнэт үйлдвэр” төрийн өмчит үйлдвэрийн газрын орон тооны хязгаарыг 7128 (долоон мянга нэг зуун хорин найм) байхаар тогтоосугай.

3. Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны ““Эрдэнэт үйлдвэр” төрийн өмчит үйлдвэрийн газрын зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаарыг өөрчлөн батлах тухай” 119 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Ц.БАЯР-ЭРДЭНЭ

132001222

